



**“ЦЕМЕНТ ШОХОЙ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар A1160

Хөтөл

**Ажилтан сонгон шалгаруулах
журам батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 8.1, 8.9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанийн “Ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг компанийн хэмжээнд мөрдлүүлэн, хэрэгжүүлж ажиллахыг Хүний нөөцийн хэлтсийн даргын үүргийг түр гүйцэтгэгч (А.Буяндэлгэр)-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хүний нөөцийн газрын даргын үүргийг түр гүйцэтгэгч (А.Галбаатар)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн A/16 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.НАРАНБААТАР



АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг үндэслэн “Цемент шохой” ТӨХК-д ажлын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх өндөр мэдлэг, боловсрол, мэргэшлийн бэлтгэл, туршлага, ур чадвар бүхий ажилтан сонгон шалгаруулж авах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Ажилтныг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, шударга, ил тод байх, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

Хоёр. Сонгон шалгаруулалтын үе шат

2.1 Компанийн хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтыг дотоод болон гадаад эх үүсвэрээс сонгон шалгаруулна.

2.2 Ажлын байрны онцлог, шаардлагыг харгалзан компанийн ажилтнуудыг албан тушаал дэвших замаар дотоод эх үүсвэрээс сонгон шалгаруулж шилжүүлэн ажиллуулж болно.

2.3 Гадаад эх үүсвэрээс ажилтан сонгон шалгаруулахдаа ажлын байрыг нээлттэйгээр тавигдах шаардлагад нийцүүлж зарлана.

2.4 Сонгон шалгаруулалтыг Хүний нөөцийн хэлтэс, харъяалах хэлтэс, алба, нэгжийн даргыг оролцуулан зохион байгуулна.

2.5 “Сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудас”-д хүний нөөцийн хэлтсийн дарга холбогдох нэгжийн дарга, мэргэжилтнүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд уг шийдвэрийг хүний нөөцийн мэргэжилтэн хадгална.

2.6 Ажлын байрны захиалга: Тухайн хэлтэс, алба, нэгж нь орон тооны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу сул болон шинээр бий болсон ажлын байранд ажилтан авах хэрэгцээг тодорхойлж захиалгаа Хүний нөөцийн хэлтэст “Ажлын байрны захиалга авах хуудас”-аар ирүүлнэ.

2.7 Ажлын байрыг зарлах: Тухайн нэгжийн ажлын байрны захиалгын дагуу ажлын байрны онцлог шаардлагыг хангасан зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (цахим хуудас, zangia.mn)-ээр нийтэд мэдээллэнэ.

2.8 Сонгон шалгаруулалт: Сонгон шалгаруулалт нь дараах үе шатаас бүрдэнэ.
Үүнд:

2.8.1 Анкетын шалгаруулалт: Ажил горилогчоос анкет, хавсралт материалыг цахим хэлбэрээр болон цаасаар ирүүлснийг хүлээн авна. Ирсэн анкетийн сонгон шалгаруулалтыг үнэлгээний хуудсаар ажлын 3 өдрийн дотор Хүний нөөцийн хэлтэс хийнэ.

2.8.1.1 Ажил олгогчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлох,

2.8.1.2 Өмнө нь тус компанид хөдөлмөрийн ноцтой зөрчил (согтууруулах ундаа хэрэглэсэн, эд хөрөнгийн хохирол учруулсан) гаргаж ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээ цуцлагдаж байсан ажил горилогчийг сонгон шалгаруултад оруулахгүй.

2.8.2 Мэргэжлийн ур чадвар тогтоох шалгалт: (онолын болон мэргэжлийн ур чадварын шалгалт авах):

2.8.2.1 Анкетийн сонгон шалгаруулалтад тэнцсэн ажил горилогчоос мэргэжил ур чадварын шалгалт авна. Тэнцээгүй ажил горилогчийн анкетыг бусад ажлын байранд нөөцөнд авна.

2.8.2.2 Онолын шалгалтын материалыг нэгжийн инженер техникийн ажилтан болон Сургалт хөгжлийн мэргэжилтэн нар боловсруулж тестээр шалгалт авна.

2.8.2.3 Хүний нөөцийн мэргэжилтэн, тухайн нэгжийн мэргэжлийн ажилтны хамт ур чадвар, туршлагыг тогтоох байдлаар холбогдох нэгжийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан шалгалтыг 2 хоногийн дотор авч үнэлнэ.

2.8.2.4 Мэргэжлийн ур чадварын шалгалтад хангалтгүй үнэлгээ авсан ажил горилогчийг тухайн ажлын байрны ярилцлагад оруулахгүй бөгөөд тохирох ажлын байрны нөөцөд бүртгэнэ.

2.8.3 Ярилцлага (хувь хүний хандлага, туршлага, тогтвортой байдал):

2.8.3.1 Анкетын сонгон шалгаруулалт, мэргэжлийн ур чадварын шалгалтад тэнцсэн ажил горилогчийг хүний нөөцийн мэргэжилтэн ярилцлагад урина.

2.8.3.2 Ярилцлагыг өмнөх ажлын туршлагад үндэслэсэн асуулт асууж “ярилцлагын үнэлгээний хуудас”-аар үнэлгээ өгнө.

2.8.3.3 Ажил горилогчтой хийх ярилцлагыг ажлын байрны онцлогоос шалтгаалан тухайн ажлын байрны захиалга өгсөн нэгжийн удирдлагыг оролцуулан хүний нөөцийн хэлтсээс багийн ярилцлага хийж санал гаргана.

2.8.3.4 Ярилцлагад тэнцсэн буюу сонгон шалгаруулалтад тэнцсэн ажил горилогчийг холбогдох газрын даргад танилцуулна.

2.9 Туршилтын хугацаагаар ажиллуулах: Сонгон шалгаруулалтад тэнцсэн ажил горилогчийг туршилтын хугацаагаар ажиллуулах тушаалын төслийг 2 хоногийн дотор боловсруулан Гүйцэтгэх захиралд танилцуулж баталгаажуулна. Туршилтын хугацаа нь 2 хүртэл сар байна.

2.10 Тэнцсэн ажил горилогч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:


2.10.1 Эрүүл мэндийн хуудас

2.10.2 Танилцуулах хуудас

2.10.3 Ажилласан жил тооцох Нийгмийн даатгалын тодорхойлолт /E-mongolia/

2.11 Сонгон шалгаруулалттай холбогдон гарах зардлыг “Цемент Шохой” ТӨХК жил бүр төсөвтөө тусгасан байна.

2.12 Шинэ ажилтныг компанийн үйл ажиллагаа соёл, дотоод дүрэм, журамтай танилцуулан, ажлын орчин, шаардлагатай мэдээллээр хангах, үүрэгт ажлыг



гүйцэтгэхэд чиглүүлэх зорилгоор "Дасан зохицох хөтөлбөр"-т хамруулна. Дасан зохицох хөтөлбөрийг Хүний нөөцийн хэлтсээс хэрэгжүүлнэ.

2.13 *Үндсэн ажилтнаар гэрээ байгуулах:* Үндсэн ажилтнаар ажиллуулах эсэхийг туршилтын хугацаа дууссан ажилтны гүйцэтгэсэн ажлын тайланг харгалзан Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

2.14 Гүйцэтгэсэн ажлын тайлангийн дүгнэлтээр туршилтын хугацаанд хангалттай үр дүн гаргаагүй ажилтныг тухайн ажлын байранд тэнцээгүй гэж үзэх бөгөөд шалтгааныг тухайн ажилтанд танилцуулж үргэлжлүүлэн гэрээ байгуулахаас татгалзана.

2.15 Туршилтын хугацааны ажлын тайланг дүгнэж дэмжсэн шийдвэр гарснаар үндсэн ажилтнаар ажиллуулах бөгөөд ажилтантай Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, ажилд томилсон тухай Гүйцэтгэх захирлын тушаал гарна.

Гурав. Нөөц бүрдүүлэх

3.1 Сонгон шалгаруулалтад 70-аас дээш оноо авсан иргэдийг нөөцийн жагсаалтанд оруулах ба 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр хадгална.

3.2 Ажил горилогчийн нөөцийн жагсаалтад бүртгэлтэй иргэн өмнөх шалгаруулалтад өрсөлдсөн албан тушаал /ажлын байр/-ын сул орон тоо гарсан тохиодолд энэ журмын 3.1-д заасан хугацааны дотор шууд ажлын байраар хангагдах эрхтэй. Харин өмнөх шалгаруулалтад өрсөлдсөнөөс өөр албан тушаалд ажиллахыг хүсвэл сонгон шалгаруулалтад дахин орно.

Дөрөв. Дотоод эх үүсвэрээс сонгон шалгаруулалтанд орох ажилтанд тавигдах шаардлага

4.1 Ажилтан өөрийн хүсэлтээр сонгон шалгаруулалтанд оролцохыг хүсвэл харъяа хэлтсийн удирдлагаас зөвшөөрөл авч, Хүний нөөцийн хэлтэст өргөдөл гаргаж шийдвэрлүүлэх бөгөөд өргөдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.

4.2 Жилд нэгжүүдийн онцлогоос хамааруулан 5-15 хүнийг шилжүүлж болох ба компанийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байна.

Тав. Ажил горилогчийн бүрдүүлэх материал

5.1 Ажил горилогч нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- 5.1.1 Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 5.1.2 3% цээж зураг (3x4 хэмжээ)
- 5.1.3 Ажилд орохыг хүсэгчийн анкет
- 5.1.4 Боловсролын диплом, хуулбар
- 5.1.5 Иргэний үнэмлэхний хуулбар

Зургаа. Бусад зүйл

6.1 Ажилтан сонгон шалгаруулахад харъяа газрын дарга, нэгжийн дарга журамд заагдаагүй нөхцлөөр нөлөөлөхийг хориглоно. Мөн тухайн нэгжийн ажилтныг сонгон шалгаруулахад бусад нэгжийн дарга нар хөндлөнгөөс нөлөө үзүүлэх эрхгүй.



6.2 Компанийн хүний нөөцийн стратеги төлөвлөлт, бодлоготой уялдуулан Хүний нөөцийн хэлтэс нь энэ журмын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

6.3 Ажилтан сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг Дотоод хяналтын хэлтсээр хянан шийдвэрлүүлж, хариуг ажил горилогчид мэдэгдэнэ.

6.4 Журмыг зөрчсөн тохиолдолд компанийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлагыг хүлээлгэнэ.

6.5 Энэхүү журам нь Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.


-oOo


A handwritten signature in black ink, located in the bottom right corner of the page. The signature is stylized and appears to be a personal name.

"Ажилтан сонгон шалгаруулах журам"-ын 01 дүгээр хавсралт



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ





АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГЫН МАЯГТ

Захиалагч хэлтэс, үйлдвэр:

Захиалгын маягтын дугаар:

1. Захиалга өгсөн хэлтэс, үйлдвэр, албаны дарга:

Овог, нэр	Албан тушаал (хэлтэс, үйлдвэр, алба)	Гарын үсэг	Огноо

2. Захиалгын төрөл: Ажлын байрны захиалга

3. Захиалгад тусгагдах мэдээлэл:

№	Захиалгын дэлгэрэнгүй агуулга	Огноо	Бусад

Захиалгыг хүлээн авсан ажилтан: /...../
огноо.....

Захиалга боловсруулж хүлээлгэн
өгсөн ажилтан: /...../
огноо.....

4. Маягтад хавсаргасан баримтыг дурдах:

- 4.1
- 4.2
- 4.3
- 4.4
- 4.5

- 1. ЗУХНГ-ын дарга /
- 2. ЕИБҮТГ-ын дарга /
- 3. ХНХ-ийн дарга /
- 4. дарга /

АНКЕТИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ХИЙХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС


Сонгон шалгаруулалт хийгдэх ажлын байр:


Тавигдах шаардлага:			Авах оноо	Ажил горилгчийн нэр 1	Ажил горилгчийн нэр 2	Ажил горилгчийн нэр 3
№	Үндсэн чиглэл	Шалгуур үзүүлэлт				
Анкетийн сонгон шалгаруулалт						
1	Холбогдох мэргэжлийн чиглэл	Холбогдох мэргэжлийн чиглэлээр их дээд, сургууль	5			
2		"Цемент Шохой" ТӨХК-ийн дэргэдэх сургалтын төв	4			
3		Барилгын материал үйлдвэрлэлийн сургууль	3			
4		Бусад	2			
5		Мэргэжил тохирохгүй	0			
6	Нас	40-с дээш нас	2			
7		30-35 нас	5			
8		25-29 нас	4			
9		18-24 нас, 35-40 нас	3			
10	Ажилласан жилийн туршлага	5-аас дээш жил	5			
11		3-4 жил	4			
12		1-2 жил	2			
13		0	0			
14	Анкет бөглөсөн байдал	Анкетад хавсаргах материалыг бүрэн ирүүлсэн	5			
15		Анкетад хавсаргах материалыг дутуу ирүүлсэн	4			
16		Анкетад хавсаргах материалыг ирүүлээгүй	1			
Нийт			20	0	0	0
Нэмэлт оноо						
17	Урлаг спорт	Мэргэжлийн зэрэгтэй	5			
18		Хангалттай сайн	2			
19		Хэвийн	0			

Үнэлгээ хийсэн: Хүний нөөцийн мэргэжилтэн

Хянасан: ХНХ-ийн дарга

Хэлтэс, үйлдвэр, албаны дарга





“Ажилтан сонгон шалгаруулах журам”-ын 04 дүгээр хавсралт

ОНОЛЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сонгон шалгаруулалт хийгдэх ажлын байр:

2022.08.05


№	Үндсэн чиглэл	Шалгуур үзүүлэлт	Авах оноо	Ажил	Ажил	Ажил
				горилогчийн нэр 1	горилогчийн нэр 2	горилогчийн нэр 3
				Авсан оноо		
Онолын шалгалтын тест						
1	IQ шалгах	Сэтгэн бодох чадвар шалгах тест	40			
2	Мэргэжлийн	Тухайн мэргэжлийн онолын тест	60			
		Нийт	100			

Үнэлгээ хийсэн: Хүний нөөцийн мэргэжилтэн

Хянасан: ХНХ-ийн дарга

Хэлтэс, үйлдвэр, албаны дарга

.....
.....
.....

“Ажилтан сонгон шалгаруулах журам”-ын 05 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Сонгон шалгаруулалт хийгдэх ажлын байр:

2022.08.05


№	Үндсэн чиглэл	Шалгуур үзүүлэлт	Авах оноо	Ажил	Ажил	Ажил
				горилогчийн нэр 1	горилогчийн нэр 2	горилогчийн нэр 3
				Авсан оноо		
Онолын шалгалтын тест						
1	Мэргэжлийн	Тухайн мэргэжлийн ур чадварыг шалгах	75			
2	Бусад	Тухайн ажлын байранд тохирох ХАБЭА, болон бусад шалгуур	25			
		Нийт	100			

Үнэлгээ хийсэн: Хүний нөөцийн мэргэжилтэн

Хянасан: ХНХ-ийн дарга

Хэлтэс, үйлдвэр, албаны дарга

.....
.....
.....

АЖИЛД АВАХ ЯРИЛЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Ажил горилогчийн овог нэр:	Сонирхож буй албан тушаал:	Ярилцлага хийсэн огноо:
----------------------------	----------------------------	-------------------------

№	Үнэлгээний үзүүлэлт	Үнэлгээ				
		5	4	3	2	1
1.	Цаг баримтлал					
2.	Өөрийгөө танилцуулах байдал					
3.	Анкетийн асуултад хариуцлагатай хандсан байдал					
4.	Ойлгох чадвар					
5.	Харилцааны чадвар					
6.	Өөртөө итгэлтэй байдал					
7.	Ур чадварын өөрийн дүгнэлт					
8.	Компанийн талаар мэдлэгтэй эсэх					
9.	Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх төлөвлөгөө					
10.	Хэтийн зорилго					
11.	Тогтвор суурьшилтай байдал – гадаад явах, суралцах					
12.	Өмнө авч байсан цалин, одоогийн цалингийн хүлээлтийн талаар					

Нийт дундаж оноо: _____ (1-5 хүртэл)

Ярилцлага хийсэн албан тушаалтны шийдвэрийн дүгнэлт:

Шийдвэр: Дараагийн шатанд оруулах
 Өөр ажлын байранд тохирох эсэхийг судла

Нөөцөнд авах
 Татгалзах

Ярилцлага хийсэн:

Хүний нөөцийн хэлтсийн дарга /

/

Нэгжийн дарга /

/

Эрүүл мэндийн хуудас

Огноо: он сар өдөр

Овог: Нэр:

Нас: Хүйс: /эр, эм/

Албан тушаал: –д ажиллах тул
эрүүл мэндийн үзлэгт оруулж, дүгнэлт гаргаж өгнө үү?

Цээж зураг

№	Үзлэгийн нэр	Үзлэгт орсон огноо	Онош	Эмчийн гарын үсэг
1	Дотор			
2	Мэдрэл, сэтгэц			
3	Чих, хамар, хоолой			
4	Нүд			
5	Шүд			
6	Мэс засал, гэмтэл			
7	Зүрх судас			
8	Арьс, өнгө /харшил/			
9	Эмэгтэйчүүд			
10	Рентген оношилгоо			
11	ЭХО			
12	БЗДХ			
13	Үйлдвэрийн эмч			
14	Сүрьеэ			
15	Бусад			

Эрүүл мэндийн дүгнэлт:

.....
.....

Дүгнэлт гаргасан ерөнхий эмч: /

..... он сар өдөр



Зааварчилгааны хяналтын хуудас

ХАБЭА-ын хяналтын инженер

1. Овог нэр _____
2. Төрсөн он, сар, өдөр _____
3. Мэргэжил, тусгай мэргэжил _____
4. Нэгжийн нэр _____
5. Хэлтэс _____
6. Хамрагдсан сургалтын сэдэв _____
7. Ажлын байр _____
8. Шалгалтын оноо _____ Хувиасны хэмжээ _____ Гутлын хэмжээ _____
9. Урьдчилгаа зааварчилгаа өгсөн _____ / _____
Гарын үсэг _____ Овог, нэр _____
10. Урьдчилгаа зааварчилгаа авсан _____ / _____
Гарын үсэг _____ Овог, нэр _____
11. Зааварчилгаа өгсөн _____ он _____ сар _____ өдөр

Холбогдох нэгж

Зааварчилгааны төрөл _____

/ажлын байрны анхан шатны төлөвлөгөөг бүс/

Зааварчилгааны сэдэв _____

Шалгалтын оноо _____

Зааварчилгаа өгсөн _____ / _____
Гарын үсэг _____ Овог, нэр _____

Зааварчилгаа авсан _____ / _____
Гарын үсэг _____ Овог, нэр _____

Ажиллуулахыг зөвшөөрсөн _____ он _____ сар _____ өдөр

Ажиллуулахыг зөвшөөрсөн _____ /гарын үсэг/

Танилцуулах хуудас

_____ он _____ сар _____ өдөр

_____ чех, нэгжийн дарга _____

_____ овогтой _____

.....ажиллуулах саналтай байна.

Захиргаа удирдлага, хүний нөөцийн газрын дарга _____

Ерөнхий инженер бөгөөд

Үйлдвэрлэл технологийн газрын дарга _____


Хүний нөөцийн хэлтсийн дарга _____

Харьяа нэгжийн дарга _____

Ажиллахыг зөвшөөрсөн _____



"Ажилтан сонгон шалгаруулах журам"-ын 08 дугаар хавсралт



“Ажилтан сонгон шалгаруулах журам”-ын 09 дүгээр хавсралт

ШИНЭ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

20... оны ... сарын ... өдөр

1. Ажил горилогчийн мэдээлэл					
Овог:		Регистрийн дугаар:			
Нэр:		Утасны дугаар:			
2. Ажлын байрны мэдээлэл					
Харъяалах нэгж					
Албан тушаал					
Ажлын байрны зэрэг					
3. Шалгалтын үнэлгээ					
Үзүүлэлт	Анкет	Онолын мэдлэг	Ур чадвар	Ярилцлага	Нийт оноо
Авбал зохих	20	30	30	20	100
Авсан оноо					
4. Сонгон шалгаруулалтын ажилтнуудын санал					
					Баталгаажуулалт
Нэгжийн дарга				 гарын үсэг
				 Овог нэр
Хүний нөөцийн хэлтсийн дарга				 гарын үсэг
				 Овог нэр
5. Танилцсан. Холбогдох газрын дарга					
Газрын дарга/ /					